

## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН 2020 ОНД НЭМЭЛТЭЭР ИМПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоол, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2020 онд нэмэлтээр импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.
2. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын дагуу хуулийн хугацаанд зохион байгуулахыг ажлын хэсэг (Т.Гантогтох)-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад тус тус даалгасугай.
3. Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (Э.Цолмонжаргал)-т үүрэг болгосугай.

САЙД Ч.УЛААН